



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 19/70

Мандалговь

“Өвс тэжээлийн агуулах саравч шинээр
барих ажил /Баянжаргалан, Эрдэнэдалай сум/
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил /Баянжаргалан, Эрдэнэдалай сум/” -ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын Газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Э.Хөхөөхүү (Иргэний төлөөлөл)

Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)

Ө.Дугармаа (Зах зээл ба бэлчээрийн удирдлагын
хөгжил төслийн зохицуулагч)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын ХАА
хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Энхтуяа)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060277